



**“ШИВЭЭ-ОВОО”
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 26/04

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирал томилох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, 80 дугаар зүйлийн 80.2, 81 дүгээр зүйлийн 81.5.2 дахь хэсэг, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2026 оны 03 дугаар сарын 01/336 дугаар албан бичиг, Нэр дэвшүүлэх хорооны 2026 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн санал, дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гүйцэтгэх захирлын нээлттэй сонгон шалгаруулалтын үр дүнгээр Гомбодорж овогтой Батсуурийг “Шивээ-Овоо” ХК-ийн Гүйцэтгэх захирлаар томилсугай.

2. Гүйцэтгэх захирал Г.Батсуурьтай холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд онцгой нөхцөлтэй, хугацаатай хөдөлмөрийн гэрээ байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Ц.Төгсбуян)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулж, бүртгүүлэхийг Захиргаа, хүний нөөцийн бодлогын хэлтсийн дарга (Ч.Энхжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ТӨГСБУЯН